

БАРЬЦААНЫ ГЭРЭЭ
(Дансны орлого барьцаалах)

2022оны 12сарын 30-ны өдөр

Дугаар: БГ-ДБ-АДС2022-12

Улаанбаатар хот

136/22

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гэрээний талууд

1.1.1. Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө, 19 байр, 12 дугаар давхар хаягт байрлах, улсын бүртгэлийн 9011680088, регистрийн 6196233 дугаартай “Ди Би Эм лизинг” ХХК (цаашид “Барьцаалагч” гэх) түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Н.Цэрэнсодном;

1.1.2. Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8 дугаар хороо, УС 15, 1-0 тоотод байрлах, улсын бүртгэлийн 000199140, регистрийн РД:6021646 дугаартай “Амгалан дулааны станц” ТӨХК (цаашид “Барьцаалуулагч” гэх) түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал М.Мөнхөө;

1.1.3. Монгол улс Улаанбаатар хот 15160 Сүхбаатарын талбай 5, Голомт банкны Төв байр хаягт байрлах улсын бүртгэлийн 9016001014, регистрийн 2075377 дугаартай Голомт банк (цаашид “Банк” гэх) түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Норихико Като , (цаашид хамтад нь “Талууд” гэх).

1.2. Энэхүү Дансны орлого барьцаалах гурван талт гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г Монгол Улсын Иргэний хуулийн 13 дугаар бүлэг, 445-448 дугаар зүйл, Банкны тухай хуулийн 11 дүгээр зүйл, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 3 дугаар бүлэг, 29 дүгээр зүйл, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль, Барьцаалагчийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 10 дугаартай тогтоолыг тус тус үндэслэн байгуулав.

1.3. Гэрээний зорилго нь Барьцаалагч болон Барьцаалуулагчийн хооронд 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан СТГ-22/01 дугаартай Санхүүгийн түрээсийн гэрээ (цаашид “Түрээсийн гэрээ” гэх)-ний үүргийн гүйцэтгэлийг хангахтай холбогдуулан Барьцаалуулагчийн Банкан дахь харилцах дансны одоо байгаа болон ирээдүйд бий болох мөнгөн хөрөнгийг барьцаалах, тухайн дансны мөнгөн хөрөнгөнөөс Түрээсийн гэрээнд заасан төлбөрийг үл маргах журмаар суутган авахтай холбоотой харилцаа, Талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлон зохицуулахад оршино.

Барьцаалуулагчийн баталгаа, зөвшөөрөл

1.4. Барьцаалуулагч нь Гэрээний 2.1-д заасан дансны эзэмшигч бөгөөд уг дансанд байгаа болон орж ирэх мөнгөн хөрөнгийг барьцаалах зөвшөөрлийг зохих журмын дагуу авсан болох, үүнээс өмнө өөр үүргийн барьцаанд тавиагүй, бусад ямар нэг байдлаар аливаа маргаанд холбогдолгүй бөгөөд энэ харилцах данснуудын талаар гуравдагч (эзэмшигчээс өөр) этгээдийн эдлэх эрх байхгүй болохыг үүгээр гэрчилж байна.

1.5 Барьцааны зүйлийн талаар Гэрээний 1.4-д заасан асуудлаар маргаан гарсан тохиолдолд Барьцаалагч нь Иргэний хуулийн 154 дүгээр зүйлд зааснаар аливаа гуравдагч этгээдээс давуу эрхтэй болохыг хүлээн зөвшөөрөв.

1.6. Барьцаалагчаас ирүүлсэн төлбөрийн мэдэгдлийн дагуу Гэрээний 2.1 дэх хэсэгт заасан Голомт банк дахь данснаас үл маргах журмаар суутган шилжүүлэх үүрэг буюу зөвшөөрлийг Иргэний хуулийн 445 дугаар зүйлийн 445.4 дэх хэсэгт заасны дагуу Банканд үүгээр олгож байна.

1.7. Санхүүгийн түрээсийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах тухай Барьцаалагчийн мэдэгдлийн дагуу Барьцаалуулагчийн данснаас үл маргах журмаар суутгал хийн Барьцаалагчийн данс руу шилжүүлж буй үйлдэл нь Банкны тухай хуулийн 11.2, Банк эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-т заасны дагуу Барьцаалуулагчийн төлбөрийн даалгавраар хийсэн төлбөр тооцоо гэж тооцохоор талууд харилцан тохиролцсон болно.

1.8. Энэхүү гэрээнд заасны дагуу барьцааны зүйлийн бодит байдал, орлого, зарлага болон уг дансыг эзэмшигч этгээдийн талаарх лавлагаа, хуулга, дансны битуумж болон бусад этгээдийн өмнө хүлээсэн мөнгөн төлбөрийн үүргийн талаарх мэдээллийг барьцаалагчийн бичгээр ирүүлсэн хүсэлтийг үндэслэн гаргаж өгөхийг барьцаалуулагч үүгээр зөвшөөрч байна. Энэхүү зөвшөөрлийг Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.1 дэх хэсэгт заасан харилцагчийн бичгээр өгсөн зөвшөөрлөд тооцогдоно.

ЗӨВШӨӨРСӨН *(Цолцэв Б.)* ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ М.МӨНХӨӨ/

Хоёр. Барьцааны зүйл

2.1. Барьцаалуулагч нь Түрээсийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангахаар доорх дансан дахь мөнгөн хөрөнгө, дансны орлого, түүн дээр нэмэгдүүлэн хийсэн бусад бүх орлого, үр шим, тэдгээрийг захиран зарцуулснаас олсон орлогын хамт (цаашид “Барьцааны зүйл” гэх) барьцаалуулж байна:

№	Барьцааны зүйлийн тодорхойлолт, төрөл	Дансны дугаар	Дансны төрөл	Харилцан тохиролцсон үнэлгээ
1	Харилцах дансан дахь мөнгөн хөрөнгө, дансны орлогууд (одоо байгаа болон ирээдүйд бий болох бүх орлого)	Голомт банк дахь 3105103284 дугаар данс	Харилцах данс	-

2.2. Барьцаалсан хөрөнгийн нийт дүн нь Гэрээний гуравдугаар зүйлд заасан Барьцаалагчийн шаардлагыг нөхөн төлүүлэхэд хүрэлцэхгүй бол Барьцаалуулагчийн бусад эд хөрөнгөөс гаргуулах эрхийг Барьцаалагч эдэлнэ.

2.3. Барьцаалуулагчийн борлуулалтын үйл ажиллагаанаас орж ирсэн орлогыг төвлөрүүлэх данс (энэ гэрээний 2.1-д зааснаас бусад) шинээр нээх болон өмнө нээгдсэн бусад дансанд борлуулалтын орлогыг төвлөрүүлэх тохиолдолд Барьцаалагчид Барьцаалуулагч мэдэгдэх ба тэрхүү дансны орлогыг энэхүү Гэрээний барьцааны зүйл гэж үзнэ.

2.4. Барьцааны зүйлийг захиран зарцуулснаас олсон орлого гэж барьцаа хөрөнгийг худалдан борлуулах болон бусад байдлаар гүйлгээнд оруулснаас олсон эд хөрөнгө, мөнгө, мөнгөтэй адилтгах хөрөнгө, барьцаа хөрөнгө гэмтсэн, устсантай холбоотой гэм хор учруулсны төлбөр, дайчлан гаргуулсны нөхөн олговор болон даатгалын нөхөн төлбөрийг хэлнэ.

2.5. Гэрээнд заасан барьцааны зүйл болох Барьцаалуулагчийн дансан дахь мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээг зогсоох нь Барьцаалуулагчийн хүсэлтийн дагуу түр зогсоосон гэж үзэхээр талууд харилцан тохиролцов.

Гурав. Барьцаагаар хангагдах үүрэг, хугацаа

3.1. Барьцаагаар хангагдах үүргийн хэмжээ нь Түрээсийн гэрээний үндсэн төлбөр болон дагалдах үүрэг болох түрээсийн хүү, алданги, шүүхийн зардал, Барьцааны зүйлийг арчлан хамгаалахад гарсан зардал, уг эд хөрөнгөтэй холбоотойгоор төлсөн татвар, хураамж, төлбөр болон Барьцаалагчид учирсан бусад хохирлын нийлбэрээр тодорхойлогдоно.

3.2. Барьцаагаар хангагдах шаардлагын хэмжээ нь түрээсийн үндсэн төлбөр болох Түрээсийн гэрээгээр тодорхойлогдох бөгөөд 55,882,154,239.00₮ (Тавин таван тэрбум найман зуун наян хоёр сая нэг зуун тавин дөрвөн мянга хоёр зуун гучин есөн) төгрөгийн үндсэн төлбөр болон түрээсийн хүү, алданги, Барьцааны зүйлийг худалдан борлуулахад гарсан зардал, улсын тэмдэгтийн хураамж, шүүхийн зардал, Барьцааны зүйлийг арчлан хамгаалахад гарсан зардал уг эд хөрөнгөтэй холбоотойгоор төлсөн татвар хураамж, төлбөр холбогдох бусад зардал болон Барьцаалагчид учирсан бусад хохирлын нийлбэрээр тодорхойлогдоно.

3.3. Барьцаагаар хангагдах үүргийн хугацаа нь үндсэн үүрэг болон дагалдах үүргийг бүрэн гүйцэтгэж, Барьцаалагч бүрэн хохиролгүй болсноор, эсхүл барьцаа хөрөнгөөр Түрээсийн төлбөрийн үндсэн болон дагалдах үүргийг бүрэн ханггуулснаар дуусгавар болно.

Дөрөв. Талуудын эрх үүрэг

4.1. Барьцаалагч нь дараах эрхтэй:

4.1.1. Банкнаас Гэрээний 2.1-д заасан Барьцааны зүйл болон түүнийг эзэмшигч этгээдүүдийн талаар бүхий л лавлагаа авах, дансны хуулга гаргуулах (ийнхүү авсан нь Банкны тухай хуулийн 7.2.1-д зааснаар буюу Барьцаалуулагчийн зөвшөөрлөөр авсанд тооцогдоно.)

4.1.2. Барьцааны зүйлийн бодит байдал, орлого, зарлага болон эзэмшигчийн мэдээллийг Банканд мэдэгдэл өгсний үндсэн дээр шалгах;

4.1.3. Барьцаалуулагч нь Түрээсийн гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд Барьцаалагч нь Банканд мэдэгдэл хүргүүлэн үүргийн гүйцэтгэлээ ханггуулах болон Барьцаагаар хангагдах шаардлагын хэмжээгээр данснаас зарлага гаргах эрхийг хязгаарлах;

4.1.4. ... /Эх үүсвэрийн гэрээг үндэслэх, эсхүл байхгүй бол тус заалтыг хасах/ байгуулсан гэрээний үндсэн дээр Барьцаалуулагчийн зөвшөөрөлгүйгээр түрээсийн төлбөр шаардах эрхээ шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн тохиолдолд барьцааны эрхийг хамт шилжүүлэх;

4.1.5. Гэрээний 4.1.2-т заасан хяналтын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь ямар нэгэн саад тогтор учруулсан тохиолдолд Барьцаалагч нь Түрээсийн гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах.

4.2. Барьцаалагч нь дараах үүрэгтэй:

4.2.1. Гэрээний 4.1.3-т заасан мэдэгдэлд Түрээсийн гэрээний хавсралтад заасны дагуу Барьцаалуулагчийн төлбөл зохих төлбөрийн дүн, данснаас суутган шилжүүлэх төлбөрийг хүлээн авах дансны дугаарыг тус тус тодорхой тусгаж, тухайн мэдэгдлийг Гэрээний Хавсралтаар баталгаажуулах;

4.2.2. Барьцаалуулагчаас ирүүлсэн барьцаа цуцлах мэдэгдлийг Барьцаалагч зөвшөөрсөн тохиолдолд мэдэгдэл хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор цуцлах мэдэгдлийг цахим мэдээллийн санд бүртгүүлэх.

4.3. Барьцаалуулагч нь дараах эрхтэй:

4.3.1. Барьцаагаар хангагдах шаардлага дуусгавар болсон тохиолдолд барьцаа цуцлуулах тухай мэдэгдлийг Барьцаалагчид бичгээр ирүүлэх;

4.3.2. Түрээсийн гэрээгээр хүлээсэн үүргээ хэсэгчлэн буюу бүрэн биелүүлсэн нөхцөлд Түрээсийн төлбөрийн дүнд харгалзах үнийн дүнтэй барьцааны эд хөрөнгийг чөлөөлүүлэх тухай хүсэлт гаргах;

4.3.3. Талуудаас Гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар болон зохих ёсоор биелүүлэхийг шаардах;

4.3.4. Барьцаа хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хангуулах тухай мэдэгдэл хүлээн авах хүртэл хугацаанд барьцааны зүйлийг Гэрээнд заасан нөхцөлөөр ашиглах, үр шимийг хүртэх.

4.4. Барьцаалуулагч нь дараах үүрэгтэй:

4.4.1. Барьцаалагчийг Гэрээнд заасан заасан эрхээ хэрэгжүүлэх бүхий л нөхцөл, боломжоор хангаж, саад учруулахгүй байх;

4.4.2. Барьцаалуулагч нь барьцаанд бариулсан дансыг өөрчлөх, хаалгах, давхар барьцаалах тохиолдолд Барьцаалагчид урьдчилан мэдэгдэж, албан бичгээр зөвшөөрөл авах;

4.4.3. Барьцаалуулагч нь барьцааны зүйл болох дансны хуулгыг Барьцаалагчаас шаардсан тухай бүр ирүүлэх;

4.4.4. Барьцаалуулагч нь Түрээсийн гэрээнд заасан үүргээ биелүүлэгүй тохиолдолд Барьцаалагч нь Банканд мэдэгдэл хүргүүлэн үүргийн гүйцэтгэлийг хангуулах бөгөөд Гэрээний 2.1-д заасан данснаас уг гүйлгээг хийхэд ямар нэгэн саад учруулахгүй байх;

4.4.5. Барьцаанд бариулсан дансыг бусад төлбөрийн үүргээс ангид байлгах, бусад барьцаалахгүй байх;

4.4.6. Түрээсийн гэрээний дагуу бүрдүүлсэн эх үүсвэрээр бий болгосон төслийн орлогыг түрээсийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу түрээсийн төлбөрийг төлөхөд бүрэн хүрэлцэхүйц байхаар Гэрээний 2.1-д заасан дансанд төвлөрүүлэх, уг дансны орлогоос Түрээсийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах;

4.4.7. Барьцааны мэдэгдлийг цахим мэдээллийн санд бүртгүүлэх, бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлийн хугацааг сунгах болон лавлагаа авах үйлчилгээний хураамжийг хариуцах.

4.5. Банк нь дараах эрхтэй:

4.5.1. Барьцаалуулагчийн түрээсийн төлбөр, түүний хүүний эргэн төлөлтийн талаарх мэдээг Барьцаалагчаас гаргуулан авах;

4.5.2. Барьцаалагчаас ирүүлсэн мэдэгдэл, түүнд хавсаргасан баримт бичиг нь гэрээний нөхцөлд нийцэгүй бол Барьцаалуулагчийн данснаас мөнгөн хөрөнгийг суутгах боло зарлагын гүйлгээг зогсоохоос татгалзах;

4.5.3. Барьцаалуулагчаас Гэрээний хугацаанд Банкнаас тогтоосон шимтгэл, хураамжийг “Банкны үйлчилгээний хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөл”-д заасны дагуу авах;

4.5.4. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг талуудаас шаардах.

4.6. Банк нь дараах үүрэгтэй:

4.6.1. Гэрээний 6.1-д заасан мэдэгдлийг хүлээн авмагц 6.2-д заасан хугацаанд Барьцаалуулагчийн харилцах данснаас Барьцаалагчийн мэдэгдэлд дурдагдсан гэрээний 2.1 дэх хэсэгт заасан үнийн дүнгээс хэтрэхгүй мөнгөн хөрөнгийг суутган авч, Барьцаалагчийн дансанд шилжүүлэх;

4.6.2. Гэрээнд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэх нөхцөл боломжоор Барьцаалагч, Барьцаалуулагчийг хангах;

4.6.3. Барьцаалагч хүсэлт гаргасан тохиолдолд барьцааны зүйл болох дансыг эзэмшигч этгээдүүдийн талаар лавлагаа, хуулгыг гаргаж өгөх.

5.1. Барьцаалуулагч нь Түрээсийн гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн, түрээсийн төлбөр, түүний хүүгийн төлбөрийг Түрээсийн гэрээний хавсралтад заасан эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөөгүй, түрээсийн мөнгөн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаагүй, Түрээслүүлэгчийн зүгээс Санхүүгийн түрээсийн болон Барьцааны гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй эсхүл Түрээсийн гэрээний хугацаа дуусгавар болсон болон Барьцаалуулагч Гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн бол барьцааны зүйлээр Түрээсийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах эрх буюу барьцаагаар хангагдах шаардлага Барьцаалагчид үүснэ.

Зургаа. Барьцааны эрх хэрэгжүүлэх ажиллагаа

6.1. Барьцаагаар хангагдах шаардлага үүссэн тохиолдолд Барьцаалагч нь Барьцаалуулагчийн зөрчлийг дурдаж, Гэрээний 2.1 дэх хэсэгт заасан дунгээс хэтрэхгүй мөнгөн дүнтэй тэнцэх төлбөрийг гаргуулах тухай Барьцаалагчийн эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга (тэмдэг)-тэй, Гэрээний Хавсралтад заасан мэдэгдлийг Банканд бичгээр хүргүүлж, Иргэний хуулийн 453.2, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 57.5-д заасны дагуу үүргийн гүйцэтгэлийг үл маргах журмаар хангуулах буюу энэ тохиолдолд Барьцаалуулагчийн төлбөрийн даалгавраар гүйлгээ хийгдсэнд тооцохоор харилцан тохиролцов.

6.2. Банк нь Гэрээний 6.1-д заасан мэдэгдлийг хүлээн авмагц Барьцаалуулагчийн харилцах данснаас Барьцаалагчийн мэдэгдэл дурдагдсан мөнгөн хөрөнгийг суутган авч, Барьцаалагчийн дансанд мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор шилжүүлнэ.

6.3. Барьцаалагч нь Гэрээний 6.1-д заасан мэдэгдлийг Банканд хүргүүлэхдээ дараах зүйлийг тодорхой тусгана:

6.3.1. Барьцаалуулагчийн Түрээсийн гэрээний хавсралтад заасны дагуу төлбөл зохих төлбөрийн дун;

6.3.2. Барьцаалуулагчийн данснаас шилжүүлэх төлбөрийг хүлээн авах Барьцаалагчийн дансны дугаар.

6.4. Барьцаалуулагчийн дансанд байгаа мөнгөн хөрөнгө нь мэдэгдэлд заасан дунгээс бага байгаа тохиолдолд Банк нь дансанд байгаа мөнгөн хөрөнгөөс дансны доод үлдэгдлийг үлдээж, бусад мөнгөн хөрөнгийг Барьцаалагчийн дансанд шилжүүлнэ.

6.5. Банк нь Гэрээний 6.4-т заасны дагуу дутуу шилжүүлсэн бол мэдэгдэл дурдсан үнийн дунгээс шилжүүлсэн дүнг хасаж, үлдсэн дүнгийн хэмжээнд, дансанд нь мөнгөн хөрөнгө байхгүй бол мэдэгдэл дурдсан нийт үнийн дунгээр дансны зарлагын гүйлгээг зогсоож, орлогын гүйлгээ орж ирсэн тохиолдолд Барьцаалагчид шилжүүлнэ.

6.6. Барьцаалагчаас Банканд барьцаалсан данснуудын зарлагын гүйлгээ хийх эрхийг сэргээх тухай мэдэгдлийг албан бичгээр хүргүүлсэн тохиолдолд данснуудаас зарлагын гүйлгээ хийх Барьцаалуулагчийн эрхийг сэргээнэ.

6.7. Барьцаалуулагч Барьцаалагчтай байгуулсан Түрээсийн гэрээний үүргээ зөрчсөн тохиолдолд барьцааны зүйл болох данснуудын зарлагын гүйлгээг зогсоох тухай Банканд мэдэгдэл хүргүүлнэ. Энэхүү зарлагын гүйлгээг зогсоох дүнг Барьцаалагчийн мэдэгдлээр тогтоох бөгөөд Банк Барьцаалагчийн мэдэгдлийг хүлээн авсан даруйдаа тус хэмжээгээр зарлагын гүйлгээг зогсоох үүрэгтэй. Энэ тохиолдолд Барьцаалуулагчийн зөвшөөрлийг авах шаардлагагүй бөгөөд Талууд Барьцаалуулагчийн хүсэлтийн дагуу зарлагын гүйлгээг түр зогсоосон гэж үзэхээр харилцан тохиролцов.

Долоо. Барьцааны мэдэгдэл бүртгүүлэх

7.1. Барьцаалагч нь Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд заасны дагуу барьцааны мэдэгдлийг цахим мэдээллийн санд бүртгүүлэх, бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлийн хугацааг сунгуулах мэдэгдлийг, Гэрээнд заасан мэдээллүүдийн хамт “Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийг бүртгэх цахим мэдээллийн сан”-д бүртгүүлж байхыг Барьцаалуулагч үүгээр зөвшөөрч байна.

7.2. Барьцаалагч нь эрх бүхий байгууллагаас барьцааны мэдэгдлийн бүртгэлийн лавлагааг бичгээр авах эрхтэй бөгөөд лавлагаа авах зөвшөөрлийг Барьцаалуулагч үүгээр зөвшөөрч байна.

7.3. Барьцаагаар хангагдах шаардлага дуусгавар болсон тохиолдолд Барьцаалуулагч барьцаа цуцлуулах тухай мэдэгдлийг Барьцаалагчид бичгээр хүргүүлнэ.

7.4. Барьцаалуулагчаас ирүүлсэн барьцаа цуцлах мэдэгдлийг Барьцаалагч зөвшөөрсөн тохиолдолд мэдэгдэл хүлээн авснаас хойш З хоногийн дотор Барьцаалагч нь цуцлах мэдэгдлийг цахим мэдээллийн санд бүртгүүлнэ.

Найм.Гэрээний хугацаа

8.1. Гэрээ нь Түрээсийн гэрээнд заасан Барьцаалуулагчийн хүлээх үүрэг, тухайлбал түрээсийн үндсэн төлбөр, хүү, алданги, мөн түрээсийн төлбөрийг эргэн төлүүлэхтэй холбогдон гарсан зардал зэргийг бүрэн төлж дууссанаар буюу Барьцаалагч бүрэн хохиролгүй болсон нөхцөлд дуусгавар болно.

Ес.Маргаан шийдвэрлэх

9.1. Гэрээтэй холбогдсон маргааныг шийдвэрлэхдээ хуульд өөрөөр заагаагүй бол Гэрээ, түүний салшгүй хэсэг болон дагалдах нэмэлт өөрчлөлт, хавсралтад заасныг нэн тэргүүнд баримтална.

9.2. Гэрээ нь Монгол Улсын хууль тогтоомжийг үндэслэн хийгдсэн бөгөөд түүний дагуу зохицуулагдана.

9.3. Гэрээний үүргийн биелэлтийн явцад гарах аливаа маргааныг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

9.4. Хэрэв Гэрээний 9.3-т заасны дагуу зөвшилцөлд хүрч чадаагүй тохиолдолд маргааныг Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

Арав.Бусад зүйл

10.1. Гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж, нотариатаар гэрчлүүлснээр хүчин төгөлдөр болж, барьцааны мэдэгдлийг “Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийг бүртгэх цахим мэдээллийн сан”-д бүртгүүлнэ.

10.2. Гэрээ нь Барьцаалагч, Барьцаалуулагчийн хооронд байгуулсан Түрээсийн гэрээ болон тус гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар байгуулсан Барьцааны гэрээнүүдийн салшгүй хэсэг болно.

10.3. Гэрээтэй холбоотой аливаа мэдэгдэл, албан бичгийг талууд Гэрээнд заасан хаягаар илгээнэ. Хаяг өөрчлөгдсөн тохиолдолд мэдэгдэх нь талуудын үүрэг ба хаяг өөрчлөгдсөнөөс мэдэгдэл, албан бичиг хүрээгүйн хариуцлагыг мэдэгдэл, албан бичиг хүргүүлсэн тал хариуцахгүй болно.

10.4. Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлт нь гагцхүү бичгээр үйлдэгдэж, талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж, баталгаажуулснаар хүчин төгөлдөр гэж тооцогдоно.

10.5. Гэрээнд хэрэглэсэн нэр томьёог Гэрээнд өөрөөр заагаагүй бол Турээсийн гэрээнд заасан утгаар ойлгоно.

10.6. Гэрээг 3 хувь үйлдсэн бөгөөд хувиуд хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН:

Барьцаалагчийг төлөөлж:



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Н.ЦЭРЭНСОДНОМ

СТУХАХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН
Н.БАДРАЛ

САНХҮҮГИЙН
ТҮРЭЭСИЙН
МЭРГЭЖИЛТЭН
Э.БАТ-ЭРДЭНЭ

Бат-эрдэн

Барьцаалуулагчийг



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
М.МОНХӨӨ

ДУЛААНЫ
СТАНЦ
ТӨХК


ЕРОНХИЙ
ИНЖЕНЕР
Э.МОНХЖАРГАЛ

Дорж

СЭЗХ-ИЙН ДАРГА,
ЕРӨНХИЙ НЯГТЛАН
БОДОГЧ:
Ө.УДВАЛ

С.У.

Банкийг төлөөлж:



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
НОРИХИКО КАТО

ИРГЭДИЙН БАНКНЫ
ГАЗРЫН ЗАХИРАЛ
Ц.БАЙГАЛМАА

Номин

Гэрээг хянасан:

“Ди Би Эм лизинг” ХХК-ийн хуульч:

2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр

Д. Номин

/Д.Номин/

2022 оны 12-р сарын 22-ны өдрийн
БГ-ДБ-АДС2022-12 дугаартай
Дансны орлого барьцаалах тухай
Гэрээний Хавсралт.

Хаанаас: “Ди Би Эм лизинг” ХХК

Хэнд: Голомт банк

Агуулга: Төлбөр шилжүүлэх тухай

Огноо:

“Ди Би Эм лизинг” ХХК болон “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн хооронд 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр байгуулагдсан СТГ-22/01 дугаартай Санхүүгийн түрээсийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангахтай холбогдуулан “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн Танай банкан дахь 3105103284 тоот харилцах данс дахь одоо байгаа болон ирээдүйд бий болох мөнгөн хөрөнгийг 2022 оны 12-р сарын 30-ны өдрийн БГ-ДБ-АДС2022-12 дугаартай Дансны орлого барьцаалах тухай гэрээгээр барьцаалсан.

“Амгалан дулааны станц” ТӨХК нь Санхүүгийн түрээсийн гэрээний Хавсралт 2-т заасан эргэн төлөлтийн хуваарийн дагуу 20.. оны ..-р сарын ..-ны өдөр төлөх нийт (.....) төгрөгийн түрээсийн төлбөрийг хуваарыт хугацаанд нь төлөөгүй тул Танай банктай байгуулсан “Дансны орлого барьцаалах гэрээ”-ний дагуу “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн 3105103284 тоот харилцах дансны орлогоос төгрөгийг банкан дахь “Ди Би Эм лизинг” ХХК-ийн тоот харилцах дансанд шилжүүлж өгнө үү.

МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛСЭН:

“Ди Би Эм лизинг” ХХК-ийн
Гүйцэтгэх захирал

Н.ЦЭРЭНСОДНОМ